



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 4/10

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний талаар иргэдээс мэдээлэл авах зурагт хуудасны хэмжээ загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийтийн тээврийн үйлчилгээний талаар иргэдээс санал хүсэлт болон гомдол хүлээн авах мэдээлэл бүхий зурагт хуудасны тээврийн хэрэгслийн гадна талд байрлах загвар, хэмжээг нэгдүгээр хавсралтаар, дотор талд байрлах зурагт хуудасны загвар, хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэдээлэл бүхий зурагт хуудсыг батлагдсан загварын дагуу байрлуулсан эсэхэд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т, Техникийн үзлэг оношлогооны төв /Ц.Нанжид/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын 1-д заасан мэдээлэл бүхий зурагт хуудсыг батлагдсан загварын дагуу хэвлэж 2019 оны хаврын техникийн үзлэг, оношлогооноос өмнө нийтийн тээврийн хэрэгслийн заасан хэсэгт байршуулж ажиллахыг тус газартай гэрээгээр ажиллаж буй нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч дарга /Х.Булгаа/-д даалгасугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР

Нийслэлийн Тээврийн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын  
12-ны өдрийн А/10 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Нийтийн тээврийн хэрэгслийн угсраа автобус, их, дунд багтаамжийн  
автобус, троллейбусны гадна талд байрлах мэдээллийн  
зурагт хуудасны өнгө, хэмжээ, байрлал



Дэвсгэр өнгө: С – 0%, М – 0%, Ү – 60%, К – 0% буюу шар өнгө

Үсгийн өнгө: С – 100%, М – 100%, Ү – 0%, К – 0% буюу хөх өнгө  
/Stroke буюу хүрээ – цагаан/

Үсгийн фронт – Tahoma /bold/

Хэмжээ: 120 см х 40 см , 100 см х 30 см

Байрлах хэсэг:

1. Угсраа автобус  
Хэмжээ / 120см х 40 см /



2. Их багтаамжийн автобус, троллейбус  
Хэмжээ / 120 см х 40 см /



3. Дунд багтаамжийн автобус  
Хэмжээ /зай талбайны хэмжээнээс хамаараад 120 см х 40 см эсвэл 100 см х 30 см/



Нийслэлийн Тээврийн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын  
12-ны өдрийн А/10 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Нийтийн тээврийн хэрэгслийн угсраа автобус, их, дунд багтаамжийн  
автобус, троллейбусны дотор талд байрлах мэдээллийн  
зурагт хуудасны өнгө, хэмжээ, байрлал



Дэвсгэр өнгө: С – 0%, М – 0%, Ү – 60%, К – 0% буюу шар өнгө

Үсгийн өнгө: С – 100%, М – 100%, Ү – 0%, К – 0% буюу хөх өнгө  
/Stroke буюу хүрээ – цагаан өнгө/

Үсгийн фонт – Tahoma /bold/

Хэмжээ: 60 см х 20 см

Байрлал:

Жолоочийн бүхээгний ард талд болон буух хаалгануудын дээд хэсэгт зорчигчдод  
ил харагдах газарт байрлуулна.

